


ОХУ-ЫН “ЭРЧИМ ХҮЧНИЙ СТРАТЕГИ-2035”-Д ХИЙСЭН СУДАЛГАА



Монгол Улс түлш эрчим хүчний асар их нөөц баялагтай. Манай хойд хөрш ОХУ нь түлш эрчим хүчний үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлдэг бол өмнөд хөрш БНХАУ хэрэглээгээрээ тэргүүлдэг. Тиймээс тэдгээрийн бодлогод нийцтэй, зөрчилгүй, харилцан уялдаатай байдлаар Монгол улсын түлш эрчим хүчний салбар хөгжих нь зүй ёсны хэрэг юм. Энэ удаад судлаач Ж.Золжаргал, Академич П.Очирбат нарын ОХУ-ын “Эрчим Хүчний Стратеги-2035”-д хийсэн судалгаанаас товчлон танилцуулж байна.



Гипотетическая модель транспортно-энергетической инфраструктуры Евразии, Институт энергетической стратегии.

Түлш эрчим хүчний цогцолбор нь ОХУ-ын төсвийн 1/3, экспортын орлогын ойролцоогоор 70%, дотоодын нийт бүтээгдэхүүний 25-26%-ийг бүрдүүлдэг тул энэ салбарын төлөв байдал тус улсын эдийн засгийг бүхэлд нь тодорхойлох суурь өгөгдөл болдог.


Гэтэл орчин үеийн технологийн дэвшил нь эрчим хүчний олон төрлийн эх үүсвэрийг ашиглах, тэдгээрийг хол зайд тээвэрлэх талаар шинэ боломжуудыг нээсээр байна. Үүнээс үүдэн улс орнууд аль болох өөрт байгаа эх үүсвэрээ ашиглах, гаднаас авах эх үүсвэрээ газарзүйн хувьд болон нэр төрлийн хувьд олшруулахыг эрмэлзэж байгаа нь ОХУ-ын зах зээлийг хумих болжээ. Мөн 2014 оноос эхэлсэн геополитикийн хямрал, Оросын эсрэг хориг арга хэмжээ, дэлхий нийтийн эдийн засгийн өсөлтийн удаашрал, нефтийн үнийн уналт зэрэг гадаад хүчин зүйлс ОХУ-ыг эрчим хүчний салбарт явуулах бодлогоо эргэн харахад хүргэжээ.

Түүнчлэн тус улсын шатах ашигт малтмалын ордуудын олборлолтын нөхцөл хүндэрч, алслагдмал ордуудыг ашиглах хэрэгцээ шаардлага бий болж байгаа, технологийн хоцрогдол ба гадаадаас хамаарсан байдал, дэд бүтэц, үйлдвэрийн бааз хуучирсан зэрэг дотоод хүчин зүйлсийг тооцоолохын сацуу нөгөө талаас 2035 он хүртэл ДНБ-ийг 1.9 дахин өсгөх эдийн засгийн үндсэн зорилгодоо хүрэхийн тулд түлш эрчим хүчний цогцолборын стратегийн зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замуудаа тодорхойлон гаргасан байна.

Нэн тэргүүнд дотоодын эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжлийн хэрэгцээг бүрэн хангахын тулд цахилгаанжуулалтыг нэмэгдүүлж, эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээ ба түгээлтийн ухаалаг сүлжээ байгуулснаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулна гэж төлөвлөжээ.

Дэлхийн эрчим хүчний салбарт тэргүүлэх нөлөөгөө хадгалахын тулд Дорнод Сибир, Алс Дорнодод түлш эрчим хүч, дэд бүтцийн томоохон төслүүд хэрэгжүүлж, Ази Номхон далайн чиглэлд экспортын зах зээлийг өргөжүүлэх. Европын зах зээлд уламжлалт нөлөөгөө батгаж, Евроазийн эдийн засгийн холбооны хүрээнд түлш эрчим хүчний нэгдсэн систем бий болгож, Арктикийн эрэг орчмын нүүрсустөрөгчийн нөөцийг ашиглах бэлтгэлийг хангах. Түлш эрчим хүчний цогцолборын гадаадын технологиос хамааралтай байдлаас гарч, Оросын технологийг хөгжүүлж, улмаар дэлхийн хэмжээнд түгээн дэлгэрүүлнэ гэсэн зорилтууд тавьжээ.

Бүс нутгийн байдлаар авч үзвэл ОХУ-ын Европын хэсэгт ДНБ-ын 70%, эрчим хүчний хэрэглээний 60% төвлөрсөн хэрнээ эрчим хүчний эх үүсвэрийн олборлолтын 80%-иас дээш хэсэг нь зүүн хойд нутагт байрладаг. Түүхий эдийг ингэж олон мянган километр тээвэрлэх нь ихээхэн алдагдалтай тул томоохон боловсруулах үйлдвэрүүдийг ОХУ-ын Азийн хэсэгт шилжүүлэн байгуулах шаардлага үүссэн байна. Цаашдаа Европын хэсэгт эрчим хүчний хэмнэлтэд гол ач холбогдол өгөх бол Урал, Баруун Сибирийн нефть хийн хуучин ордуудын олборлолтын түвшинг барих, харин Зүүн Сибир, Алс Дорнодын нефть, хий, нүүрс, усны баялгийг эргэлтэд оруулах, тэдгээрийг дагасан дэд бүтцийн асар том бүтээн байгуулалт хийхээр төлөвлөн, хэрэгжүүлж эхлээд байна. ▶



121 сая тонныг экспортолсон байна.

Европын хэсэгт эрчим хүчний хэмнэлт, үр ашигтай хэрэглээг голчлон анхаарах

Арктикийн нүүрсустөрөгчийн баялгийг ашиглахад геополитик болон технологийн томоохон сорилтууд тулгарна. Энэ бүс нутгийн баялгийг 2035 оноос хойш ашиглах бэлтгэлийг хангана.

Урал, Баруун Сибирийн нефть хийн ордуудын олборлолтыг тогтворжуулах, технологийн дэвшлийг ашиглах

Дорнод Сибир, Алс Дорнодод эрчим хүч-аж үйлдвэрлэлийн кластерууд, тэдгээрийг дагасан дэд бүтцийг хөгжүүлнэ. Эдийн засгийн өсөлт нь ОХУ-ын бусад бүс нутгаас илүү эрчимтэй явагдана.

Дорнод Сибир-Номхон Далай нефть дамжуулах хоолойн схем

Нефтепровод Восточная Сибирь — Тихий океан



(Эх үүсвэр: <http://sdelanounas.ru/blogs/15936/>)

ОХУ-ын байгалийн хийн олборлолтын шинээр бий болох төвүүд



(<http://newsruss.ru>)

Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл нь 2014 онд 1062 тэрбум кВт-цаг байсан бол экспорт нь 2008-2014 онд 3-18 тэрбум кВт-цаг байжээ. Түүнчлэн дэлхийн цөмийн эрчим хүчний 7.1%-ийг үйлдвэрлэж, энэ хэмжээгээрээ АНУ, Францын дараа гуравдугаарт ордог.

Сүүлийн жилүүдэд Дорнод Сибир, Якутын нефть, байгалийн хийн шинэ ордуудыг ашиглаж эхэлсэн. Номхон далайн Козьмино боомт хүртэл ВСТО 1, 2, Сковородино-Мохэ-Дацин чиглэлийн нефть


дамжуулах хоолойнууд ашиглалтад орсон. Бованкево-Ухта, Сахалин-Хабаровск-Владивосток, Джубга-Лазаревское-Сочи чиглэлийн хий дамжуулах хоолойнууд байгуулагдаж, Сила Сибири, Северный поток хоолойнуудын бүтээн байгуулалт эхэлсэн. Цаашдаа 2035 он хүртэл нефтийн жилийн олборлолтыг 525 сая тонноос багагүй хэмжээнд барих бөгөөд Ази Номхон далайн орнууд руу гаргах нефтийн хэмжээг 51-110 сая тонн хүргэж, өнөөгийнхөөс 2 дахин нэмэгдүүлэх зорилт тавьсан. Харин хийн олборлолтыг 821-885 тэрбум куб метр, Азийн зах зээлд нийлүүлэх экспортын хэмжээг 14-128 тэрбум куб метр хүргэж өсгөхөөр төлөвлөжээ.

ОХУ-ын нефть-хий-химийн түүхий эдийн үйлдвэрлэл сүүлийн зургаан жилд 37%-иар, тэдгээрийг ашиглах химийн үйлдвэрлэл 15%-иар, хуванцарын үйлдвэрлэл 29%-иар өссөн. Цаашдаа Дорнод Сибир, Алс Дорнодод нефть-хий-химийн том хэмжээний боловсруулах үйлдвэрүүдийг кластераар хөгжүүлж, хуванцарын үйлдвэрлэлийг өнөөгийнхөөс 5 дахин нэмэгдүүлж, олон төрлийн эцсийн бүтээгдэхүүн экспортолно.

Нүүрсний салбар сүүлийн жилүүдэд эрчимтэй өсч экспорт нь 1.7 дахин нэмэгдсэн ба голчлон Азийн зах зээлд гаргаж байна. Якутын Эльгинское ордыг БАМ-тай төмөр замаар холбож олборлолтыг эхлүүлсэн. Байгалийн чанадын Апсатское ордыг ашиглаж эхэлсэн ба Инаглинское, Ургальское ордуудын дэд бүтцийг хөгжүүлэх шийдвэр гарсан. Тувагийн Улуг-Хемийн сав газрын Элегестское ордыг ашиглахаар бэлтгэж, Транссибиртэй холбох төмөр замын бүтээн байгуулалт эхэлсэн. Амур мужийн Ерковецкий, Гербикино-Огоджинское сав газрын нүүрсийг олборлох төслийг боловсруулж байгаа.

Нүүрсний тээвэр логикийн чадамж дээшилж, Ванино, Посьет, Находка, Усть-Луга зэрэг далайн боомтын нүүрс тээвэрлэх хүчин чадал нэмэгдсэн байна. Цаашдаа төмөр замын нэвтрүүлэх чадлыг нэмэгдүүлэх, тарифыг урт хугацаагаар тогтоох, Номхон далайн боомтууд дахь нүүрсний терминалуудын хүчин чадлыг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх арга хэмжээнүүд авах юм байна. Тува, Якут, Байгалийн чанадад нүүрсний олборлолтын шинэ төвүүдийг бий болгоно. Мөн хөрш улсууд руу эрчим хүч экспортлох зорилгоор нүүрсний цахилгаан станцууд шинээр байгуулахаар төлөвлөж, эхний ээлжинд Амурская-Хэйхэ чиглэлийн 500кВ шугамыг ашиглалтад оруулжээ. Энэ мэтчилэн 2035 он гэхэд Оросын нүүрсний олборлолт 445 сая тонн, экспорт 206 сая тоннд хүрэх ба экспортын өсөлтийн ихэнхийг Ази Номхон далайн зах зээлд гаргах коксжих нүүрс эзэлнэ гэж тооцоолсон байна.

ОХУ-ын нүүрсний олборлолтын шинээр бий болох төвүүд



(Эх сурвалж: www.mineral.ru)

ОХУ-ын оролцоотой хэрэгжиж байгаа атомын цахилгаан станцын төслүүд



(Эх сурвалж: www.rian.ru)

Цөмийн эрчим хүчний салбарыг өргөжүүлэн хөгжүүлэхэд онцгой ач холбогдол өгч байна. Сүүлийн жилүүдэд Ростовская АЭС блок №2 1000 МВт, №3 1070 МВ, Калининская АЭС блок №4 1000 МВт-ыг ашиглалтад оруулж, Белоярская, Ростовская, Нововоронежская, Ленинградская АЭС-уудын шинэ блокийн барилга угсралт хийгдэж байна. ОХУ нь Ираны Бушар, Энэтхэгийн Кудамкулан, БНХАУ-ын Тяньаний атомын цахилгаан станцын барилга угсралтад

идэвхтэй оролцож байгаа. Мөн Беларусь, Бангладеш, Унгар, Финланд, Турк улсад атомын цахилгаан станц байгуулах хэлэлцээрт гарын үсэг зурсан. Цаашдаа ураны нөөц боломж сайтай бусад улс оронд Оросын компани хайгуул ашиглалт явуулах, ураны хамтарсан компаниуд дахь хувь эзэмшлийн хэмжээгээ нэмэгдүүлэх бодлого баримтална.

Хурдан нейтроны реактор болон ашигласан түлшиг дахин боловсруулах технологийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлж, дунд хэмжээний атомын цахилгаан станцыг олон тоогоор үйлдвэрлэж, атомын станцаас үйлдвэрлэсэн цахилгааныг экспортлох зорилт тавьжээ. Цөмийн эрчим хүчний салбарт ОХУ-ын технологи ба ажил үйлчилгээг гадаад улсууд руу экспортлохыг улстөр, эдийн засгийн бодлогоор дэмжинэ гэжээ.

Эдгээрийн үр дүнд 2015-2035 онд АЦС-уудын суурилагдсан чадал 1.4-1.7 дахин өсч нийт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд эзлэх хувь нь 17%-21% болох юм байна.

Түүнчлэн эрчим хүчний хэмнэлт, байгаль орчны нөлөөлөл, технологийн хөгжил, боловсон хүчний хангамж, хөрөнгө оруулалт, олон улсын харилцаа болон ОХУ-ын төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээг "Эрчим хүчний стратеги-2035"-д тодорхойлсон байна. ▶



“ЭРЧИМ ХҮЧНИЙ СТРАТЕГИ-2035”-ЫН ДАРААХ ЗОРИЛТУУД НЬ МОНГОЛЫН ХУВЬД ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ЮМ. ҮҮНД:

1) ОХУ нь ураны хайгуул олборлолтыг дотооддоо болон гадаадад эрчимжүүлж, цөмийн эрчим хүчний салбарт Оросын технологи, тоног төхөөрөмжийг экспортлохыг улс төр, эдийн засгийн бодлогоор дэмжинэ.

2) ОХУ-ын Азийн орнууд руу нийлүүлэх нүүрсний экспорт сүүлийн жилүүдэд эрчимтэй өссөн. Цаашдаа Дорнод Сибир, Алс Дорнодын нүүрсний олборлолт өсч, төмөр замын нэвтрүүлэх чадвар болон далайн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, БНХАУ болон Азийн бусад оронд коксжих нүүрсний нийлүүлэлтээр тэргүүлэгч орон байх зорилт тавьсан байна.

3) Дорнод Сибир, Алс Дорнодын нефть, хий, уран, нүүрс, бусад ашигт малтмалаас гадна модны баялаг ба усан цахилгаан станцын нөөц боломжийг ашигласнаар энэ бүс нутгийн эдийн засаг ОХУ-ын дунджаас илүү эрчимтэй өснө.

МОНГОЛЫН ХУВЬД АНХААРАХ АСУУДАЛ:

- Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн цөмийн эрчим хүчний хэрэглээ олон улсад өсөх нь тодорхой. Шуудхан хэлэхэд биднийг хүссэн хүсээгүй Монголын ураны нөөцийг ашиглах талаар их гүрнүүд үйл ажиллагаа явуулж л таарна. Тиймээс аль болох өөрт ашигтайгаар, хор хохирол багатайгаар энэ баялгаа ашиглах талаар стратеги судлал, шинжлэх ухаан, байгаль орчин, бизнесийн салбаруудыг хамарсан салбар хоорондын институцийг бий болгон хөгжүүлнэ.

- БНХАУ нь хүлэмжийн хийг бууруулах томоохон зорилт тавьсан тул хөрш орнуудаасаа цэвэр эрчим хүч худалдан авах сонирхолтой байгаа. Иймд Монголын ураны нөөцөд тулгуурлан Оросын техник технологи, менежментээр атомын цахилгаан станц байгуулж, БНХАУ руу эрчим хүч экспортлох нь гурван улсын ашиг сонирхолд нийцэхээр байна.

- Цөмийн эрчим хүчний салбарт ОХУ-тай түлхүү хамтарч ажилласнаар Монгол Улс дахь Оросын ашиг сонирхол нэмэгдэж, хөрш улсуудын нөлөөний тэнцвэртэй байдал сайжирна.

МОНГОЛЫН ХУВЬД АНХААРАХ АСУУДАЛ:

- ОХУ нь Ази тивийн коксжих нүүрсний зах зээл дээр Монголын томоохон өрсөлдөгч мөн бөгөөд цаашдаа нөлөө нь улам хүчтэй болно. Тиймээс Монголын нүүрсийг Транс-Сибирийн төмөр замаар дамжуулан гуравдагч оронд экспортлох боломж бараг байхгүй гэж болно.

- Монгол Улсаас БНХАУ-ын хойд хэсгийн далайн боомтууд хүртэлх зай нь ОХУ-ын нүүрсний ордуудаас тус улсын Номхон далайн боомтууд хүртэлх зайнаас хол биш. Энэ чиглэлд ОХУ-аас илүүтэйгээр Австрали, Индонези зэрэг нийлүүлэгчид хүчтэй өрсөлдөгч болно. БНЭУ, Япон, Өмнөд Солонгос гэх мэт бусад зах зээлд Монголын нүүрс өрсөлдөх боломжтой эсэх нь БНХАУ-ын нутгаар дайрах транзит тээврийн хөнгөлөлтөөс шууд хамаарна.

- Монголын нүүрсний уламжлалт зах зээл болох БНХАУ-ын баруун хойд хэсгийн хувьд Монголын нүүрс нь ОХУ болон бусад нийлүүлэгчидтэй харьцуулбал урт хугацаанд давуу байдлаа хадгалж чадна.

МОНГОЛЫН ХУВЬД АНХААРАХ АСУУДАЛ:

- Дорнод Сибир, Алс Дорнодын аж үйлдвэржилт, дэд бүтцийн бүтээн байгуулалт нь асар их хэмжээний бараа материал, хүнс, ажиллах хүчний эргэлтийг бий болгоно.

- Монголд цементийн хэт үйлдвэрлэл бий болохоор байгаа тул ОХУ руу экспортлох, үүний тулд төрийн зүгээс тээврийн зардал, гаалийн татварын дарамтыг бууруулах талаар ОХУ-тай яриа хэлэлцэр өрнүүлж дэмжих шаардлагатай. Төмөр хийц, арматурыг Монголоос нийлүүлэх боломж бас байна.

- Дорнод Сибир, Алс Дорнодын махны хэрэгцээ нэмэгдэнэ. Ажлын болон дулаан хувцас, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг хил залгаа Монголын нутгаас хангах боломжтой бөгөөд үүнд гаалийн татварын дарамтыг бууруулах талаар төрийн яриа хэлэлцээр чухал үүрэгтэй.

- “Эрчим хүчний стратеги-2035”-д ОХУ-БНХАУ хоорондын байгалийн хий, нефть дамжуулах хоолойг Монголын нутгаар дамжуулах талаар дурдаагүй байна. Хоёр хөршийг холбосон нефть-хийн хоолой, өндөр хүчдэлийн шугам барих тохиолдолд Монгол Улс түүнээс авах биш зөвхөн замаас нь бүтээгдэхүүнээ нийлүүлж экспортлох сонирхлыг л мөрдлөг болгох учиртай. Зөвхөн ОХУ-Монгол Улсын хооронд нефть, байгалийн хийн мухар хоолой тавих нь манайд ашиггүй. Нүүрснээс байгалийн хий гарган авах, мөн цахилгааны үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх нь Монголын хувьд илүү ирээдүйтэй.

4) ОХУ-ын дотоодын цахилгааны хэрэгцээ ихээхэн өсөхөөс гадна Дорнод Сибир, Алс Дорнодод усан ба нүүрсний цахилгаан станцууд шинээр барьж, их хэмжээний эрчим хүч экспортлох зорилт тавьсан байна. Мөн алслагдмал орон нутагт бага оврын бие даасан эх үүсвэрүүд болон дунд оврын атомын цахилгаан станцуудыг олноор байгуулахаар төлөвлөжээ.

5) Дорнод Сибир, Алс Дорнодын бүс нутагт хуванцар, каучук, органик синтезийн томоохон үйлдвэрүүд болон тэдгээрийг дагасан эцсийн бүтээгдэхүүний жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлж экспортыг нэмэгдүүлнэ.

7) Дэлхийн улсуудад орчин үеийн технологи нэвтрэхийн хэрээр хэрэглээний материал ба эрчим хүчний эх үүсвэрээс хамаарах хамаарал буурч байна. Ийм нөхцөлд ОХУ нь анхдагч түүхий эдийн экспортоос хэт хамаарсан байдлаа бууруулж, дэд бүтцийн бүтээн байгуулалт ба боловсруулах үйлдвэрлэлд тулгуурласан эдийн засгийн загварыг сонгохоос өөр аргагүй болж байна.

МОНГОЛЫН ХУВЬД АНХААРАХ АСУУДАЛ:

- Монголд нүүрснээс гарган авах цахилгаан эрчим хүч нь бусад улс орноос харьцангуй хямд өртөгтэй.
- Улаанбаатарын түгээх сүлжээг өргөтгөж, хүчин чадлыг өсгөх нь гэр хороололд цахилгаан халаалтын ашиглалтыг нэмэгдүүлэх өртөг өндөртэй боловч агаарын бохирдлыг бууруулах олон талт арга хэмжээний нэг болно.
- Цахилгаан машин, цахилгаан автобус, галт тэрэгний цахилгаан зүтгүүр, цахилгаан экскаватор, цахилгаан өрмийн машин зэрэг импортын түлш шатахуунаар биш дотоодод үйлдвэрлэсэн цахилгаанаар ажилладаг тоног төхөөрөмжийн ашиглалтыг нэмэгдүүлэх, тэдгээрийн үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай.
- Малчин өрхийн хэрэгцээг бүрэн хангахуйц бага оврын бие даасан эх үүсвэрийн технологийг дотооддоо хөгжүүлэх өөрийн онцлогт нийцсэн эрчим хүчний аюулгүй байдлыг бий болгоход шийдвэрлэх нөлөө үзүүлнэ.

МОНГОЛЫН ХУВЬД АНХААРАХ АСУУДАЛ:

- Энерги-химийн үйлдвэрлэл нь өндөр хөгжилтэй улс орнуудаас түүхий эдийн нөөцтэй улсууд руу шилжиж байгаа. Монголын хувьд энэ хандлагаас хоцролгүй нүүрс-химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох чиглэлээр шийдэмгий арга хэмжээ авч Азийн материалын зах зээлд бага боловч өөрийн гэсэн байр суурьтай болох нь урт хугацаандаа маш чухал ач холбогдолтой.
- Нүүрс-химийн үйлдвэрлэл нь нефть-хийн боловсруулах үйлдвэрээс өртөг зардал өндөртэй, эдийн засгийн үр ашиг багатай тул татварын онцгой хөнгөлөлт үзүүлж, хөрөнгө оруулалтыг татах, мөн ОХУ, БНХАУ-тай транзит тээвэр хийхэд ямарваа хориг саадгүй байлгах тал дээр төрийн оролцоо нэн чухал.

6) ОХУ нь эрчим хүчний салбарт тэргүүлэгчийн байр сууриа хадгалахын тулд идэвхтэй гадаад бодлого хэрэгжүүлнэ.

МОНГОЛЫН ХУВЬД АНХААРАХ АСУУДАЛ:

- Олон улсад гарч байгаа энэхүү өөрчлөлтийг анхдагч түүхий эдийн экспортоос хэт хамаарсан Монгол Улс анхаарах шаардлагатай.
- Газарзүйн байрлалын хувьд Монголын түүхий эдийн экспорт нь ганц зах зээлээс хэт хамааралтай. Иймд урт хугацаандаа эдийн засгийн бие даасан байдлаа хангахын тулд түүхий эдийг боловсруулж, тээврийн зардал даахуйц бүтээгдэхүүн үйлдвэрлэн, аль болох олон улсад экспортлох чиглэлийг баримтлахаас өөр арга үгүй.
- Цахилгаан станц, өнгөт ба хар төмөрлөгийн хайлуулах үйлдвэрлэл, химийн үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл гэх мэт эрчим хүчний зарцуулалт өндөртэй аж үйлдвэрлэлийг Монголд хөгжүүлэх нь өрсөлдөх чадвар, давуу талын хувьд илүү боломжтой. ■

МОНГОЛЫН ХУВЬД АНХААРАХ АСУУДАЛ:

- Эрчим хүчний салбарын хувьд Евроазийн интеграцид хамрагдах боломжийг Хятад-Орос-Монголын эдийн засгийн коридороор дамжуулан хэрэгжүүлэх. Ингэхдээ эрчим хүчний хэрэглэгч биш дамжуулагч бөгөөд нийлүүлэгч байр сууринаас оролцох.
- Дорнод Сибир, Алс Дорнодын хөгжлийн төлөвлөлтийг судлах нь Зүүн Хойд Азийн бүс нутагт үр ашигтайгаар хамтарч ажиллахад ихээхэн ач холбогдолтой.